**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

***Аудитын код: ХОА***-2021/104/***СТА-ТШЗ***

| | |
|---|---|
| *Цахим хуудас:* www.audit.mn<br><br>*Ховд хот*<br>2021 *он* | *Тэргүүлэх аудитор:* *Х.Болдбаатар*<br>*Утас: 70433061*<br>*Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn*<br>*Аудитын менежер:* *А.Цэцэгсүрэн*<br>*Утас:70432545*<br>*Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn*<br>*Ахлах аудитор:* *Д.Нарантуул*<br>*Утас: 70432545*<br>*цахим хаяг:* Narantuul.d@audit.gov.mn |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| *АДБОУС* | *Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт* |
| *АОУС* | *Аудитын Олон Улсын Стандарт* |
| *УСНББОУС* | *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* |
| *ТШЗ* | *Төсвийн шууд захирагч* |
| *ГИХГ* | *Гадаадын иргэн, харьяатын газар* |
| *ГИХГББДГ* | *Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газар* |

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт....................................................3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....................................................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................................................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................................................4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................................................6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................................................7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................................................8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....................Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан ....................................................9
3.1. Ерөнхий зүйл ....................................................9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....................................................10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....................................................10
3.4. Материаллаг байдал ....................................................10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....................................................10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....................................................12
3.7. Шилэн дансны мэдээлэл....................................................13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................................................13
3.9. Аудитын илрүүлэлт....................................................13
Залруулсан алдаа ....................................................14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил...Error! Bookmark not defined.
Аудитын зөвлөмж ....................................................14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....................................................14
4. Менежментийн захидал ....................................................14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....................................................15

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021-01-28 № 2/9

танай ____________-ны № ____________-т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР
БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН ДАРГА
А.ХУАНБАЙ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Гадаадын иргэн, харьяатын газар баруун бүс дэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Гадаадын иргэн, харьяатын газар баруун бүс дэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гадаадын иргэн, харьяатын газар баруун бүс дэх газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

021020074

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 88,818,125.46 | 69,471,716.33 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 88,818,125.46 | 69,471,716.33 |
| **354** | **Хангамжийн материал** | 88,818,125.46 | 69,471,716.33 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,344,000 | 5,095,050 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,368,086.56 | 13,554,046.56 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 142,000 | 8,121,388.50 |
| 35450 | Барилгын засварын материал | 405,000 | 405,000 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 63,653,738.90 | 42,296,231.27 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 332,200,321.61 | 247,253,304.33 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 332,200,321.61 | 247,253,304.33 |
| **392** | **Биет хөрөнгө** | 318,715,321.61 | 234,263,304.33 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 106,129,723.99 | 106,129,723.99 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (11,934,228.86) | (15,837,471.86) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 220,394,082.75 | 220,394,082.75 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (132,707,971.42) | (153,524,637.94) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 330,722,710.96 | 345,645,526.96 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (207,276,151.23) | (279,992,182.22) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,760,311.34 | 39,565,176.34 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (26,373,155.92) | (28,116,913.69) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,485,000 | 12,990,000 |
| 39301 | Програм хангамж | 1,980,000 | 1,980,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (495,000) | (990,000) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,000,000 | 12,000,000 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 421,018,447.07 | 316,725,020.66 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 421,018,447.07 | 316,725,020.66 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 421,018,447.07 | 316,725,020.66 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 12,000,000 | 12,000,000 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 12,000,000 | 12,000,000 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 406,179,965.87 | 301,886,539.46 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 406,179,965.87 | 403,990,500.08 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (102,103,960.62) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,838,481.20 | 2,838,481.20 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 421,018,447.07 | 316,725,020.66 |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 723,458,034.20 | 784,776,959.03 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 93,163,234.20 | 49,841,259.03 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 93,163,234.20 | 49,841,259.03 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 93,163,234.20 | 49,841,259.03 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 93,163,234.20 | 49,841,259.03 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **630,294,800** | **734,935,700** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 630,294,800 | 734,935,700 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 630,294,800 | 734,935,700 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **717,822,447.99** | **876,693,636.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **717,822,447.99** | **876,693,636.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 691,365,645.00 | 749,781,233.54 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 425,352,480.09 | 466,110,108.61 |
| 210101 | Үндсэн цалин | 298,511,978 | 303,207,489.02 |
| 210102 | Нэмэгдэл | 90,586,185.09 | 72,567,810.56 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,254,317 | 50,348,889.18 |
| 210104 | Урамшуулал | - | 39,985,919.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,371,452.37 | 56,380,840.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,798,887 | 33,694,040.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,803,565.37 | 5,673,600 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,138,000 | 4,540,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 785,000 | 1,133,200 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,846,000 | 11,339,600 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,048,100 | 21,465,278.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,265,643 | 6,894,718.67 |
| 210302 | Түлш, халаалт | 6,136,457 | 7,714,060 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,876,000 | 709,500 |
| 210304 | Байрны түрээс | 5,770,000 | 6,147,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 50,348,381.55 | 81,995,292.13 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,818,448 | 3,645,650 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,218,600 | 16,424,502.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,370,833.55 | 1,539,869.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 327,500 | 484,500 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,613,000 | 6,959,485 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 52,941,285.93 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 1,010,200 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 1,010,200 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,888,800 | 5,252,400 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 715,000 |
| 210604 | Урсгал засвар | 17,888,800 | 4,537,400 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,247,800 | 4,894,200 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,247,800 | 4,894,200 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,405,818 | 3,894,083 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000 | 432,000 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 420,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 428,018 | 443,520 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 135,600 | 135,600 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,060,000 | 1,302,000 |
| 210807 | Газрын төлбөр | 24,000 | 81,430 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 578,200 | 1,079,533 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 101,702,812.99 | 108,778,830.96 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,216,250 | 3,063,100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,718,702 | 1,423,200 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 91,767,860.99 | 104,292,530.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26,456,802.99 | 126,912,402.76 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,610,000 | 3,724,000 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,610,000 | 3,724,000 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 21,846,802.99 | 123,188,402.76 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,846,802.99 | 123,188,402.76 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 5,635,586.21 | (91,916,677.27) |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 8,312,178 | 10,187,283.35 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 8,312,178 | 10,187,283.35 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (8,312,178) | (10,187,283.35) |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | (2,676,591.79) | (102,103,960.62) |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **630,294,800** | **734,935,700** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **630,294,800** | **734,935,700** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 630,294,800 | 734,935,700 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 630,294,800 | 734,935,700 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **630,294,800** | **734,935,700** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **630,294,800** | **734,935,700** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **603,837,997.01** | **608,023,297.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 425,352,480.09 | 468,299,574.40 |
| 210101 | Үндсэн цалин | 298,511,978 | 303,207,489.02 |
| 210102 | Нэмэгдэл | 90,586,185.09 | 74,757,276.35 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,254,317 | 50,348,889.18 |
| 210104 | Урамшуулал | - | 39,985,919.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,202,665.37 | 56,380,840.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,514,600 | 33,694,040.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,803,565.37 | 5,673,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,569,000 | 4,540,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 392,500 | 1,133,200 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,923,000 | 11,339,600 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,048,100 | 21,465,278.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,265,643 | 6,894,718.67 |
| 210302 | Түлш, халаалт | 6,717,957 | 7,714,060 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,657,000 | 709,500 |
| 210304 | Байрны түрээс | 8,407,500 | 6,147,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,795,833.55 | 37,509,654 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,772,300 | 4,634,700 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,400,000 | 23,720,200 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,370,833.55 | 1,539,869 |
| 210404 | Ном, хэвлэл | 400,000 | 484,500 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,852,700 | 7,130,385 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,414,800 | 11,704,900 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 4,900,000 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 2,267,500 |
| 210604 | Урсгал засвар | 19,414,800 | 4,537,400 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,659,000 | 4,894,200 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,659,000 | 4,894,200 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,480,618 | 2,879,550 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,000 | 432,000 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 420,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 428,018 | 443,520 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 135,600 | 135,600 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,000,000 | 1,325,000 |
| 210807 | Газрын төлбөр | 24,000 | 81,430 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 500,000 | 42,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,884,500 | 4,889,300 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,361,400 | 3,466,100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,523,100 | 1,423,200 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,456,802.99** | **126,912,402.76** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,610,000 | 3,724,000 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,610,000 | 3,724,000 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 21,846,802.99 | 123,188,402.76 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,846,802.99 | 123,188,402.76 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 12,000,000 | 2,838,481.20 | 409,016,557.66 | 423,855,038.86 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (2,836,591.79) | (2,836,591.79) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **12,000,000** | **2,838,481.20** | **406,179,965.87** | 421,018,447.07 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **12,000,000** | **2,838,481.20** | **406,179,965.87** | 421,018,447.07 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **12,000,000** | **2,838,481.20** | **406,179,965.87** | 421,018,447.07 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | | (2,189,465.79) | (2,189,465.79) |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **12,000,000** | **2,838,481.20** | **403,990,500.08** | 418,828,981.28 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (102,103,960.62) | (102,103,960.62) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **12,000,000** | **2,838,481.20** | **301,886,539.46** | 316,725,020.66 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 630,294,800 | 608,447,997.01 | 734,935,700 | 611,747,297.24 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 630,294,800 | 608,447,997.01 | 734,935,700 | 611,747,297.24 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 625,394,800 | 603,837,997.01 | 731,190,900 | 608,023,297.24 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 446,759,800 | 425,352,480.09 | 567,164,700 | 468,299,574.40 |
| 210101 | Үндсэн цалин | 299,621,200 | 298,511,978.00 | 349,823,300 | 303,207,489.02 |
| 210102 | Нэмэгдэл | 105,698,600 | 90,586,185.09 | 118,169,600 | 74,757,276.35 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,440,000 | 36,254,317 | 52,382,000 | 50,348,889.18 |
| 210104 | Урамшуулал | | | 46,789,800 | 39,985,919.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,345,000 | 61,202,665.37 | 76,567,200 | 56,380,840.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,511,700 | 52,514,600.00 | 52,880,400 | 33,694,040.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,807,600 | 2,803,565.37 | 5,673,600 | 5,673,600 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,569,000 | 1,569,000 | 5,540,400 | 4,540,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 941,500 | 392,500 | 1,133,200 | 1,133,200 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,515,200 | 3,923,000 | 11,339,600 | 11,339,600 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,304,300 | 22,048,100.00 | 23,039,700 | 21,465,278.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,270,300 | 5,265,643.00 | 8,084,500 | 6,894,718.67 |
| 210302 | Түлш, халаалт | 6,869,500 | 6,717,957.00 | 7,714,200 | 7,714,060.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,657,000 | 1,657,000.00 | 1,094,000 | 709,500.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,507,500 | 8,407,500.00 | 6,147,000 | 6,147,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 45,073,800 | 44,795,833.55 | 37,556,200 | 37,509,654.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,903,300 | 5,772,300 | 4,634,700 | 4,634,700 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,400,000 | 31,400,000 | 23,720,200 | 23,720,200 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,404,400 | 3,370,833.55 | 1,582,500 | 1,539,869 |
| 210404 | Ном, хэвлэл | 400,000 | 400,000 | 484,500 | 484,500 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,966,100 | 3,852,700 | 7,134,300 | 7,130,385 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,414,800 | 19,414,800 | 11,857,800 | 11,704,900 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | | 4,900,000 | 4,900,000 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | | 2,267,500 | 2,267,500 |
| 210604 | Урсгал засвар | 19,414,800 | 19,414,800 | 4,690,300 | 4,537,400 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,659,000 | 10,659,000 | 5,964,300 | 4,894,200 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,659,000 | 10,659,000.00 | 5,964,300 | 4,894,200 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,730,600 | 6,480,618.00 | 4,151,700 | 2,879,550 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,113,000 | 3,113,000 | 1,230,900 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,000 | 280,000 | 432,000 | 432,000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | | 420,000 | 420,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 467,000 | 428,018 | 443,700 | 443,520 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 135,600 | 135,600 | 135,600 | 135,600 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,000,000 | 2,000,000 | 1,366,000 | 1,325,000 |
| 210807 | Газрын төлбөр | 156,800 | 24,000 | 81,500 | 81,430 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 578,200 | 500,000 | 42,000 | 42,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,107,500 | 13,884,500 | 4,889,300 | 4,889,300 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,415,000 | 8,361,400 | 3,466,100 | 3,466,100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,692,500 | 5,523,100 | 1,423,200 | 1,423,200 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,900,000 | 4,610,000 | 3,744,800 | 3,724,000 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,900,000 | 4,610,000 | 3,744,800 | 3,724,000 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,900,000 | 4,610,000 | 3,744,800 | 3,724,000 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 630,294,800 | 630,294,800 | 734,935,700 | 734,935,700 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 630,294,800 | 630,294,800 | 734,935,700 | 734,935,700 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 630,294,800 | 630,294,800 | 734,935,700 | 734,935,700 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 37 | 34 | 37 | 34 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26 | 23 | 26 | 23 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10 | 10 | 10 | 10 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **34** | **34** | **34** | **34** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 24 | 24 | 24 | 24 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10 | 10 | 10 | 10 |

# 3.АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. Ерөнхий зүйл

Гадаадын иргэн, харьяатын баруун бүс дэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газрын дарга А.Хуанбай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, бараа материал,нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 01 дугаар сарын 28–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ГИХГББДГазар нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт хүрсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулах гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсад зорчих түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах хувийн урилга олгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэхжүүлэх,
- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх,
- Иргэний харьяалал, цагаачлал, гадаадын гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх,
- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*

## 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Гадаадын иргэн, харьяатын баруун бүс дэх газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ГИХГ-ын дотоод аудитын хэлтсээс 2020 онд хийх хяналт шалгалт хийх төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй Ковид-19 цар тахалтай холбоотой хошлогдсон байна.

## 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 652041.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6520.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 784776.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7847.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

## 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гадаадын иргэн, харьяатын баруун бүс дэх газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 104293.4 мянган төгрөгөөр буюу 25 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Авлага | | | - |
| Бараа материал | 88,818.1 | 69,471.7 | (19,346.4) |
| Үндсэн хөрөнгө | 332,200.3 | 247,253.3 | (84,947.0) |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 421,018.4 | 316,725.0 | (104,293.4) |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | - |
| Цэвэр хөрөнгө, өмч | 421,018.4 | 316,725.0 | (104,293.4) |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 421,018.4 | 316,725.0 | (104,293.4) |

Мөнгөн хөрөнгө, авлагын данс оны эхэн, эцэст үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны үлдэгдэл 69471.7 мянган төгрөг болж 19346.4 мянган төгрөгөөр 22 хувиар буурсан нь албан хаагчдын нормын хувцсыг акталсан, шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд худалдаж авсан зарцуулаагүй 8121.3 мянган төгрөгийн шатах тослох бараа материалын үлдэгдэлтэй байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотой харьяа аймгуудын ихэнх боомтын үйл ажиллагаа явуулаагүй, хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Тайлант онд 24089.2 мянган төгрөгийн шатах тослох материалыг худалдан авалт хийж 16109.8 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 8121.3 мянган төгрөгийн бараа материалын нөөц үүсгэсэн нь шатахууны зардлын төлөвлөлттэй холбоотой, сард зарцуулах хэмжээнээс их хэмжээнээс илүү нөөцөлсөн байна.

Бараа материалын дансанд ГИХГ-аас 29312.3 мянган төгрөгийн албан хаагчдын норм хувцас, 1010.2 мянган төгрөгийн эм боох материалыг шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 725714.5 мянган төгрөг болж 14727.7 мянган төгрөгөөр өссөн нь системийн хэмжээнд хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн хөрөнгөөр 4900.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй 20142.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч нийт 25042.7 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөнөөс үнэ төлбөргүйгээр системийн дотоодод 20919.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 377 тоот тогтоолоор 5415.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, байгууллагын даргын тушаалаар албан хаагчдын нормын хувцсыг акталж устгасантай холбоотой хасагдсан байна.

Урт хугацаат өр төлбөр, богино хугацаат өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлтгүй байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 61318.9 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 43322.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь ГИХГ-аас системийн хооронд үнэ

төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө, бараа материал багассан, улсын төсвийн санхүүжилт 104640.9 мянган төгрөгөөр буюу 16.6 хувиар өссөн холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 161060.7 мянган төгрөгөөр буюу 22.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал 42947.1, нормативт зардал 1010.2, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 488.2, бараа үйлчилгээний бусад зардал 7076.0, хангамж бараа материалын зардал 31646.9, урсгал шилжүүлэг 100455.6 мянган төгрөгөөр өссөн, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4990.6, байр ашиглалтай холбоотой зардал 582.8, эд хогшил, урсгал засварын зардал 12636.4, томилолтын зардал 4353.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь 2020 онд Засгийн газраас Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээг шинэчилсэнтэй холбоотой, тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнөөс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 2189.4 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь өмнөх оны өр төлбөрийг төлснөөс шалтгаалсан байна.

## 3.6. **ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 699549.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 699549.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 71668.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 771217.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 771217.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 734935.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 734935.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 611747.3 мянган төгрөгийг зарцуулж 123188.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 611747.3 мянган төгрөг буюу 83.2 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 98865.1, шимтгэлийн зардлыг 20186.4, гэрэл цахилгааны зардлыг 1189.9, цэвэр бохир усны зардлыг 384.5, шуудан холбооны зардал 42.6, урсгал засварын зардал 152.9, дотоод албан томилолтын зардал 1070.1, БҮТЭЗ-ийн зардал 3.9, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1230.9, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 41.2, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардал 20.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээний 121937.6 мянган төгрөгөөр, 1 арга хэмжээний 20.8 мянган төгрөгөөр, 1 арга хэмжээний 1230.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь баруун бүсийн харьяа аймгуудын хилийн боомтуудын үйл ажиллагаа хэвийн явагдаагүйгээс илүү цагийн хөлс олгоогүй, 4 албан хаагч хүүхдээ асрах эхийн чөлөөтэй байсан, батлагдсан орон тоогоор ажиллаагүй зэргээс шалтгаалан хэмнэлт гарсан байна.

*Хүснэгт 3* *Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт* */ мянган,төг /*

| код | хөтөлбөр, арга хэмжээ | мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 121,937.6 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 20.8 |

| | | |
|---|---|---|
| 81522 | Гадаадын иргэдийг албан гаргах | 1,230.0 |
| | ДҮН | 123,188.4 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ГИХГББДГазрын Төрийн сан банк дахь 100160012406 тоот нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, 11 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий зарлага буюу тайлант оны эцэст улсын төсөвт татан төвлөрүүлсэн 121937.6 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, сар бүрийн төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг бүрэн мэдээлээгүй, зарим цэсэд холбогдох мэдээллийг оруулаагүй шууд илгээсэн зэрэг дутагдал байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8000.0 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт* 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 1 | 8,000.0 | 1 | 8,000.0 | | - | 100 |
| Нийт дүн | 1 | 8,000.0 | 1 | 8,000.0 | - | - | 100 |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9009.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9009.7 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний орлого зарлагын журналд журнал ваучераар орлого бууруулан санхүүжилтийг хассан 3947.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн, нэр данс зөрүүтэй ажил гүйлгээг орлого зарлагаар давхардуулан тусгасан,
2. Шатахуун түгээх байгууллагатай хийсэн гэрээний дагуу урамшуулалд олгосон 683.7 мянган төгрөгийн шатахууныг эд хариуцагчийн тайлан, санхүүгийн үр дүнгийн тайланд 683.7 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй,
3. Өмнөх онуудад ХХОАТ-тай холбоотой үүссэн өр төлбөрийг 2189.4 мянган төгрөгийг тайлант онд төлснийг өр төлбөр үүсгэж өмнөх үр дүн рүү залруулах бичилтийг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
4. Тайлант үеийн үр дүнг 2189.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан,

***Шийдвэрлэсэн нь***: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 9009.7 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудалгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. ***Бараа материалын данстай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:* Оны эцэст шатах тослох материалыг өмнөх оноос үлдэгдэл нэмэгдэж сард зарцуулах хэмжээнээс илүү нөөцөлсөн зөрчил байна.

1.2. *Эрсдэл:* Бараа материалыг хяналтгүй зарцуулах, дутах

1.3. *Өгсөн зөвлөмж*: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

2. ***Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:* Байгууллагын эд хөрөнгийг тооллого хийгдэж данс бүртгэлд байгаа боловч биетээр оршин байхгүй хөрөнгө байна.

*2.2. Эрсдэл*: Хөрөнгө дутагдах эзэнгүйдэх

*2.3. Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлэн холбогдох байгууллагад уламжилж асуудлыг шийдвэрлэх

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

### 3.*Шилэн данстай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:* Шилэн дансны хуульд заасны дагуу төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг бүрэн мэдээлээгүй, 12 дугаар сард улсын төсөвт татан төвлөрүүлсэн зарлагыг мэдээлээгүй, зарим цэсэд холбогдох мэдээллийг оруулаагүй шууд илгээсэн зэрэг дутагдал байна.

*3.2. Эрсдэл:* Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх

*3.3. Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтуудыг хэрэгжүүлэн хуульд заасан мэдээллийг олон нийтэд үнэн зөв мэдээлэх

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2021 | Аудитын нэр: | ***Гадаадын иргэн, харьяатын баруун бүс дэх газрын* 2020 *оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: ХОА-2021/104/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газар** | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шатахуун түгээх байгууллагатай хийсэн гэрээний дагуу урамшууллаар олгосон шатахууныг эд хариуцагчийн тайлан, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй орхигдуулсан | 683.7 | Залруулга хийх | Газрын дарга , нягтлан бодогч | А.Хуанбай, П.Бүрэнбат |
| 2 | Мөнгөн гүйлгээний журналд журнал ваучераар санхүүжилт буурсан бичилтийг орлого бууруулсан, нэр данс зөрүүтэй ажил гүйлгээг бүртгэсэн | 3947.1 | Залруулга хийх | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 2020 оны эцэст шатах тослох материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн их хэмжээгээр нөөцөлсөн зөрчил байна. | - | Зөвлөмж өгөх | | |
| 4 | ХХОАТ-ын өмнөх оны өглөг бүртгээгүй тайлант онд төлж тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн | 2189.4 | Залруулга хийх | | |
| 5 | Тайлант оны үр дүнг зөрүүтэй тайлагнасан | 2189.4 | Залруулга хийх | | |
| 6 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй | - | Зөвлөмж өгөх | | |
| 7 | Худалдан авах ажиллагааны тайлан, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт болон бусад мэдээллийг зарим сарууддад бүрэн байршуулаагүй, оны эцэст улсын төсөвт татан төвлөрүүлсэн мөнгийг мэдээлээгүй, мэдээлэл оруулахдаа "байхгүй" гэсэн утгаар мэдээлсэн | - | Зөвлөмж өгөх | | |
| **ДҮН** | | 9009.6 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**